

Оюу Толгойг хэн сайн мэдэх вэ?

Монгол оюутны ОЮУНЫ тайлагнал

Чингис хаан дээд сургуулийн

Олон улсын харилцааны

III курсын оюутан Б.Баттөр

Хөгжил дэвшлийг цогцлоон бүтээх хүсэл тэмүүлэлтэй, ирээдүйн их ололт амжилтын эзэд болох Монгол Улсын залгамж халаа залуу үеийнхээ төлөөлөл болж өөрийн үзэл бодол, хүсэл зориггоо Оюу Толгой компанийн ололт амжилтын нэгэн адил ОЮУН УХААН, МЭДЛЭГ ЧАДВАРАА тунгаан шүүж, нэгтгэн дүгнэсэн өөрийн бүтээлээрээ олон түмэндээ түүчээлэн хүргэж байгаадаа баяртай байна.

Улс орны хөгжил дэвшил өдрөөс өдөрт хүрээгээ тэлж, их бүтээн байгуулалтууд өрнөж буй энэ цаг үед түүнд гар бие оролцож, сэтгэл зүрх, итгэл найдвараа гээлгүйгээр улс орноо хөгжүүлэхийн төлөө эрхэм зорилт тавин ажиллаж, Монголын эдийн засаг, хүн амын амьжиргааг сайжруулах үйлсийг Оюу Толгой компанийн алсын хараадаа тулгуурлан цогцлоон бүтээж буй нь Монгол Улсын хөгжил дэвшлийн үр шимийг нэмэгдүүлэх үндсэн нөхцөл болж байна.

Хөгжил дэвшилд тэмүүлсэн үндэсний компани, аж ахуй нэгжүүдийн хувьд ХӨГЖЛИЙГ БҮТЭЭГЧ байхын төлөө хэн, хэрхэн, яаж хүчин зүтгэх ёстойг Оюу Толгой компанийн олон жилийн үйл ажиллагааны ил тод байдал, нарийн зохион байгуулалт, дотоодын ажиллах хүчний бүрдүүлэлт, ажлын үр дүнгээс тодхон харж болно.

Гадаадын хөрөнгө оруулалт улс орны хөгжил дэвшлийг дээшлүүлэх чухал ач холбогдолтой. Тэгвэл өнөөдөр дэлхийн томоохон улс гүрнүүд Монголыг дэлхийд тэргүүлэх уул уурхайн компани болох Оюу Толгой компаниар мэддэг таньдаг болсон тэд Монголд хөрөнгө оруулалт хийх сонирхолтой болсон. Тиймээс Оюу Толгой бол Монголын үндэсний үйлдвэрлэл, бүтээн байгуулалт, хөгжил дэвшлийг илэрхийлэх нэрийн хуудас нэгэнтээ болж чаджээ.

Бидний өвөг дээдэс одоогоос 5000 жилийн тэртээ одоогийн Оюу Толгойн бүс нутагт гар аргаар олборлолт явуулж байсан мэдээ бий. Энэ бол бидний оюу эрдэнийн баялгийг үр хойчдоо дархалсан өвөг дээдсийн минь түүх. Бид өнөөдөр эх түүхийг бүтээж байна. Магадгүй бидний ирээдүй хойч үе маань бидний туулж өнгөрүүлж байгаа энэ цаг үеийг дурсахдаа XXI зууны босгонд Монгол оронд өрнөж буй их бүтээн байгуулалтаар бахархах байх. Тиймээс бид техник, технологи давамгайлсан XXI зуунд Оюу Толгой компанийн үйл ажиллагаа, алсын хараад тулгуурлан хөгжил дэвшлийг бүтээн байгуулж Монголын ирээдүйн хүчирхэг эдийн засгийн чухал бааз суурийг бэлтгэх ёстой. Энэ бол улс орны маань өмнө тавигдаж буй чухал асуудал.

Оюу Толгой компанийн улс орноо хөгжүүлэхийн төлөө, ард түмнийхээ амьдралыг сайжруулахын төлөө, Монголчуудын амьдралд гэрэлт ирээдүйг бүтээхийн төлөө алс хэтийн зорилт тавин ажиллаж байна. Тэд хөгжлийг бүтээж байна, эдийн засгаа хөгжүүлж байна, ард түмэндээ үнэлэгдэж байна цаашдаа ч амжилтаа улам бататгах байх гэдэгт би эргэлзэхгүй байна.

Улс орны бүтээн байгуулалтад хувь нэмрээ оруулж, үндэсний үйлдвэрлэлийн ололт амжилтыг тээн яваа Оюу Толгой компанийн олон жилийн нөр их хөдөлмөрийн ачаар Монгол Улсын нийгмийн хөгжил дэвжин дээшилж байгаа гэдэгтэй маргах хүн үгүй бизээ.

Дэлхийн зах зээл дээр уул уурхайн бүтээгдэхүүнээ нэвтрүүлсэн тэр цаг үеэс Монгол Улс хүн төрөлхтөний хөгжил, дэвшлийн замд хөл нийлүүлэн алхах боломжийг олж авсан нь

бахархууштай. Энэхүү бахархал омогшилийг Монгол хүн бүрийн зүрх сэтгэлд бий болгосон үндэснийхээ компаниар бид бахархах ёстой. Оюу Толгойгоогоор бахархах ёстой. Өнөөдөр Оюу Толгой компани тогтсон мэргэжилтэй, тогтвортой ажлын байртай, тогтмол орлоготой залуу боловсон хүчнийг бүрдүүлж өөрийн компанийн үйл ажиллагааг өргөжүүлэн дээшлүүлж байгаа нь сайшаалтай. Энэ бол Монголын дэлхийд тэргүүлэх үндэсний компаний хөгжил дэвшил, нийгмийн хөгжлийн бодит жишээ.

Сүүлийн жилүүдэд Оюу Толгой компаниас нийгэмд чиглэсэн олон үйл ажиллагаануудыг үр дүнтэйгээр шат дараалан хэрэгжүүлж байна. Үүнээс дурдвал:

1. Байгаль орчныг хайрлан хамгаалах ялангуяа ус, хөрс, агаарын бохирдлын тулгамдсан асуудлыг эерэгээр шийдвэрлэх, сөрөг нөлөөллийг багасгах, ногоон орчинг бий болгох чиглэлээр нийгэмд уриалга болгон дэвшүүлсэн олон үйл ажиллагаа, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Энэ бол Оюу Толгойн ногоон хөгжлийн бодлого. Байгаль орчинд оруулж буй хамгийн том хөрөнгө оруулалт.

2. Оюу Толгой компани уул уурхайн компаниуд дундаас ялгарах онцлог нь бүтээн байгуулалт болон ашиглалтын явцад уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг үнэлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, мөн цаашдын уул уурхайн үйл ажиллагааг зөв зүйтэй төлөвлөх үүрэг хүлээсэн, энэ үүргээ ч сайн ухамсарладаг. Ногоон орчин бидний ирээдүй.

3. 1.4 их наяд төгрөг (1.1 тэрбум ам.доллар) – Монголын ханган нийлүүлэгчдэд зарцуулсан худалдан авалтын үнийн дүн (2010-2012 онд) энэ бол уул уурхайн салбараас Монголын ханган нийлүүлэгч үндэсний компаниудад олгож буй том боломж үр дүнтэй хамтын ажиллагаа. Бид хөгжлийг хамтдаа бүтээнэ.

4. 168 тэрбум төгрөг (126 сая ам.доллар) – Монгол Улсын мэргэжлийн боловсролын салбарт Оюу Толгойн оруулж буй хөрөнгө оруулалт. Энэ бол улс орныг цаашид авч явах шинэ залуу үеийнхний хувьд хамгийн том хөрөнгө оруулалт. Оюу Толгойтой хамт оюунлаг Монголыг бүтээцгээе.

Эцэст нь дүгнэж хэлэхэд Оюу Толгойн нийгэмд эзлэх байр суурь жил ирэх тусам нэмэгдэж байна. Үүнтэй холбоотойгоор Оюу Толгой төсөл хөтөлбөрийн талаар ард иргэдийн дунд элдэв төрлийн буруу ташаа мэдээлэл цацагдаж байгаа нь эмзэглүүштэй. Мэдээллийг ард түмэнд өгөхдөө үнэн, бодит мэдээллийг өгч байх үүргээ хэвлэл мэдээллийнхэн маань жаахан ч гэсэн ухамсарлах хэрэгтэй байна. Хэн нэгэн албан тушаалтны байр сууринаас Оюу Толгойн үйл ажиллагааг буруу зөрүү ард түмэнд ойлгуулах нь Оюу Толгой компанид цаашлаад ард иргэд, аж ахуй нэгжүүдтэй харилцах харилцаа хамтын ажиллагаанд сэв суулгах алхам болох болов уу гэж бодож байна. Улс орноо хөгжүүлэх гэж байгаа үндэснийхээ компаниа гоочилж, буруутгахын оронд бид дэмжих хэрэгтэй. Тэгж байж л улс орон маань хөгжиж дэвшинэ. Харин Оюу Толгойтой хөгжлийг бүтээх сонголтыг ард түмэн минь үнэний нүдээр олж харах болно гэдэгт би гүн бат итгэлтэй байна.

Оюу Толгой Монголын бахархал
Хөгжлийн дэвшилд хамтдаа